

ЭРЧИМ ХҮЧНИЙ НҮҮРСНИЙ ҮНЭ БҮРДЭЛТИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ (Багануур ХК ийн жишээн дээр)

Б.Хоролсүрэн*, Ё.Эрдэмбаяр, В.Данаасүрэн*****

Хураангуй: Монгол улсын эрчим хүчний гол түүхий эдийг нийлүүлэгч уурхайнуудын бүтээгдэхүүн борлуулах үнэ нь өртгөөсөө байнга доогуур байх болсон үйлдвэрлэлийн эдийн засгийн үр өгөөжийг бууруулж, жилээс жилд алдагдалтай ажиллах нөхцлийг бүрдүүлж байна. Энэ байдлаас гарах арга замыг эрэлхийлэх, эдийн засгийн эрүүл тогтолцоог бүрдүүлэх нь түлш эрчим хүчний салбарын шийдвэрлэх тулгамдсан асуудал мөн тул энэхүү өгүүлэлд түлш эрчим хүчний салбарын бүтээгдэхүүний өртгийн бүтэц, үнэ бүрдэх механизмд шинжилгээ хийж, боловсронгуй болгох талаар тодорхой санал дүгнэлт өгсөн болно.

Түлхүүр үг: Нүүрсний үнэ бүрдэлт, уул уурхай, эрчим хүч.

Нүүрсний салбарын өнөөгийн байдал

Монгол улс дотоодын нийт цахилгаан эрчим хүчнийхээ 80 хувийг, дулаан хангамжийн бараг 90 орчим хувийг нүүрсээр хангаж байгаа тул нүүрс бол Монгол улсын үйлдвэр, аж ахуй, ахуйн түлшний хэрэглээ, эрчим хүчний зориулалтын үндсэн ашигт малтмал төдийгүй уул уурхайн гаралтай экспортын бүтээгдэхүүний гол баялаг юм.

Монгол улсын нүүрсний уурхайнуудын нийлбэр хүчин чадал 110,5 сая тоннд хүрч байгаа ба үүнээс дээд хүчин чадлын 8 уурхай болон их хүчин чадлын 6 уурхайн нийлбэр хүчин чадал нь 97,5 сая тонн/жил байна. Өнгөрсөн онд 40 гаруй аж ахуйн нэгж 25,4 сая тонн нүүрсийг олборлосон нь нийт хүчин чадлын 22,1%-ийг ашиглажээ. Нүүрс борлуулалт 1.364.832,6 сая төгрөгт хүрсэн ба үүний (1 тн нүүрсний үнэ 10,9-91,6 мянган төгрөг, дундаж үнэ 51 мянган төгрөг) 96,3% буюу 24,3 сая тонныг нь 13 аж ахуйн нэгж олборложээ.

*МУИС-ийн, Бизнесийн сургууль, (E-mail) khorlo_b@yahoo.com


**МУИС-ийн, Бизнесийн сургууль, (E-mail) erkashine@yahoo.com

***МУИС-ийн, Бизнесийн сургууль, (E-mail) vdanaa@yahoo.com

Нэмэгдэж байгаа нүүрсний ихэнх нь экспортлогдож байгаа ба бүтээгдэхүүнээ экспортлодог уурхайнуудын хувьд зах зээлийн өрсөлдөөний хүчин зүйлүүдээс хамааралтай ажиллах тул алдагдал хүлээж ажиллах нөхцлийг зөвшөөрдөггүй. Харин дотоодын нүүрсний хэрэгцээ нь харьцангуй тогтвортой хэмжээнд байсаар ирсэн ба дулаан, эрчим хүчний шинэ эх үүсвэрүүд ашиглалтад орж эхлэхэд эрчим хүчний нүүрсний хэрэгцээ нэмэгдэхээр төлөвлөгдөж байна. Одоогоор дотоодын, тэр дундаа төвийн бүсийн эрчим хүчний хэрэгцээг хангадаг 3 уурхай гол үүргийг гүйцэтгэж байгаа ба эдгээр уурхайнууд харьцангуй олон жил олборлолт явуулсан, техник технологи хуучирсан, уул геологийн нөхцөл хүндэрч, хөрс хуулалт, хоцрогдолтой явагддаг зэрэг шалтгаанаар жил бүр алдагдалтай ажиллаж, санхүүгийн хувьд биеэ даах боломжгүй байсаар байна.


Төвийн бүсийн нүүрсний хэрэглээний бүтэц болон нүүрсний уурхайн уулын ажлын хэмжээг дараах зургуудаар харуулья.

Зураг 1. Төвийн бүсийн эрчим хүчний нүүрсний хэрэглээний бүтэц, сая тонноор



Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл, салбарын тайлангууд

Зураг 2. Төвийн бүсийн эрчим хүчний нүүрсний уурхайнуудын уулын ажлын хэмжээ, сая м³



Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл, салбарын тайлангууд

2015 онд “Багануур” ХК 19,5 сая.м³ хөрс хуулж 3.7 сая.тн нүүрс “Шивээ Овоо” ХК 7.04 сая.м³ хөрс хуулж 1.7 сая.тн нүүрс, “Шарын гол” ХК 4.6

сая.м³ хөрс хуулж 0.76 сая.тн нүүрс тус тус гаргасан байна. 2015 оны уулын цулын үзүүлэлтийг харвал “Шарын гол” ХК 2008 оноос 5.3 дахин өссөн үзүүлэлттэй “Шивээ Овоо” ХК 2008 оноос 1.54 дахин өссөн үзүүлэлттэй, 2008 оноос 1.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Дээрхи төрийн өмч давамгайлсан нүүрсний уурхайнуудын гол хэрэглэгчид нь цахилгаан, дулааны эрчим хүчний станцууд байдаг юм.

Хүснэгт 1. Төвийн бүсийн эрчим хүчний нүүрсний хэрэгцээ хангамж (2015 он, сая тн)


№	Станцууд	БН ХК	ШО ХК	ШГ ХК	Дүн
1	ДЦС-4 ТӨХК	1635.1	1633.4		3268.5
2	ДЦС-3 ТӨХК	1,266.6			1266.6
3	ДЦС-2 ТӨХК	224.5			224.5
4	ДЦС ТӨХК	107.7		272.7	380.4
5	ЭДЦС ТӨХК	-		286.2	286.2
	Нийт дүн	3234.0	1633.4	558.9	5438.0

Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл, салбарын тайлан

Эрчим хүчний нүүрсний үнэ, зардлын харьцаа

Түлш, эрчим хүчний үйлдвэрийн хэвийн, найдвартай ажиллагаа, түүхий эдийн хангамжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн Газар 2009 оны 01-р сарын 21-ний өдөр 20-р тогтоол гаргаж, эрчим хүчний зориулалтаар нийлүүлэх нүүрсний үнийг уурхайн санхүүгийн бие даасан байдлыг хангах хэмжээнд, холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж байхаар шийдвэрлэсэн боловч газар нутаг том, дэд бүтцийн хөгжил сул зэрэг шалтгааны улмаас дотоодын зах зээл дэх өрсөлдөөний нөхцөл хязгаарлагдмал, нүүрсний үнэ чөлөөт бус, уурхайнууд алдагдалтай ажилласаар байна. Нүүрсний үнийг индексжүүлэх эсвэл чөлөөлөх боломжийг судалж, нүүрсний үнэ тогтоож байгаа өнөөгийн аргачлалыг шинэчлэн эрчим хүчний нүүрс олборлогч уурхайнуудын санхүүгийн байдлыг сайжруулах, эдийн засгийн үр өгөөжийг хангах орчинг бүрдүүлэх нь хойшлуулушгүй чухал асуудал юм.

Зураг 3. Төвийн бүсийн нүүрсний уурхайнуудын нүүрсний үнэ ба зардлын харьцаа, төг/тн



Багануурын нүүрсний уурхайн олборлосон нүүрсний үнийг зах зээлийн нөхцөл байдал, техник, технологийн хүндрэл, түлш шатахуун, сэлбэг материалын үнийн өөрчлөлттэй уялдуулан тухай бүрт нь нэмэгдүүлэн тогтоож байгаагүй, олборлох өртгөөс нь доогуур хатуу барьж байснаас олон жилийн турш алдагдалтай ажилласаар ирсэн. Компани санхүүгийн чадавхигүй болж, төлөвлөгдсөн хөрөнгө оруулалт, засварын ажлуудыг хойшлуулан улмаар жил бүр өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад ч бэрхшээл учирсаар байна. Өвлийн ачааллын үед уурхайд бэлэн нүүрсний нөөц буурах, ДЦС-уудын нүүрсний нийлүүлэлт тасалдах эрсдэл үүсч болзошгүй юм.

Улсын Их Хурал 2011 оны 12 дугаар сарын 09-ны өдөр Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан гаргасан бөгөөд энэхүү хуулиар “Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлалыг батлах, тооцоог хянах” асуудлыг шинээр байгуулагдах “Эрчим хүчний зохицуулах хороо”-ны бүрэн эрхэд тусгаж өгсөн байна. Эрчим хүчний зохицуулах хороо нүүрсний үнийг тогтоохдоо үйл ажиллагааны бодит өртөг зардалд тулгуурлан тогтоож буй хэдий ч уурхайн орлого нь санхүүгийн чадавхийг хэвийн байлгахуйц хэмжээд хүрэхгүй, ирээдүйд хийх хөрөнгө оруулалт, шинэчлэлийн зардал, олон жил хуримтлагдсан өрийг барагдуулах боломжгүй байдалд хүрч байна.

Нүүрсний үнэ тогтоож буй өнөөгийн аргачлал: Монгол улсын дэд бүтцийн сайдын 2002 оны 01 дүгээр сарын 14 ны өдрийн “Нүүрсний үнэ тогтоох аргачлал батлах тухай” 07 тоот тогтоол гарч мөрдөгдөж эхэлсэн. Энэ тогтоолд дараах зарчмыг баримтална гэж заажээ.

1. Үйл ажиллагааны бодит өртөг зардалд тулгуурлах

2. Нүүрсний уурхайнуудын орлого нь, түүний санхүүгийн чадавхийг хэвийн байлгахуйц хэмжээнд байх
3. Хөрс хуулалт, нүүрс олборлолт, борлуулалтын үйл ажиллагааг тасралтгүй найдвартай хангах шаардлагад нийцүүлж өртөг зардлыг багасгах, хамгийн бага өртгийн зарчмыг баримтлах ба тарифын бүтэц нь нэгж бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд ноогдох хөрөнгө оруулалтын өгөөж, үйл ажиллагааны зардлаас бүрдэнэ гэжээ.

1. Үнийн бүтэц

Тарифын бүтэц нь нэгж бүтээгдхүүн, ажил үйлчилгээнд ноогдох хөрөнгө оруулалтын өгөөж, үйл ажиллагааны зардлаас бүрдэнэ.

2. Үнийн тооцоо

Үнэ тооцохдоо борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг /БОш/-г үйлчилгээний биет хэмжээ /Ү б.х/-нд харьцуулж тодорхойлно.

3. Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ

Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ нь үйл ажиллагааны нийт зардал /НЗ/ -ын дүн болон ашиглагдаж байгаа хөрөнгө оруулалтын өгөөжийн нийлбэрээр тодорхойлогдоно.

4. Нийт зардлын дүн

Нийт зардлын дүн /НЗ/ нь үйл ажиллагааны бүрэн өөрийн өртөг/ БӨӨ/, зээлийн хүүгийн зардал

5. Бүрэн өөрийн өртөг

Үйл ажиллагааны бүрэн өөрийн өртөг /БӨӨ/, нийт зардлын тооцоог үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үе шат бүрээр тооцно.

6. Хөрөнгө оруулалтын өгөөж

Хөрөнгө оруулалтын өгөөж /ХОө/-ийг тодорхойлохдоо хөрөнгө оруулалтын дүнг хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь /ХОөх/-иар үржүүлнэ.

7. Хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр

- Богино ба урт хугацаат зээл
- Эзэмшигчийн өмч /хувийг жигнэсэн дунджаар тооцно/

8. Өгөөж тооцох хөрөнгө оруулалт

Үйл ажиллагаатай холбогдох үндсэн хөрөнгө /ҮХ/ анхны өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хасаж тодорхойлно.

9.Өгөөж тооцох эргэлтийн хөрөнгө

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой эргэлтийн хөрөнгө /ЭХ/-өөс богино хугацаат өр төлбөр /Өбх / -ийг хасаж тодорхойлно.

2001 онд Эрчим хүчний тухай хууль батлагдан гарч, хуулийн 6.1.7 заалтад “эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлалыг батлах, тооцоог хянах” асуудлыг Эрчим хүчний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд оруулж, анх удаа нүүрсний үнийн асуудлаар хуулийн зохицуулалтыг хийсэн байдаг. Энэ заалтын дагуу дээрх 07 тоот тогтоолоор батлагдсан аргачлалыг өнөөг хүртэл мөрдөж байна. Багануур ХК ийн нүүрсний үнийг 2011 онд 2300 төгрөгөөр, 2013 онд 2000 төгрөгөөр, 2014 онд 3000 төгрөгөөр тус тус нэмж, нэг тонн нүүрсний үнийг 25,500 төгрөг болсон.

2010 оны 12-р сарын 9 өдрийн УИХ-ын 72-р тогтоолоор нүүрсний үнийг 2010-2014 хүртэл үе шаттайгаар нэмэгдүүлж, 2015 оноос эрчим хүчний нүүрсний үнийг зах зээлийн үнэд шилжүүлэн, үнийг чөлөөлөхөөр шийдвэрлэсэн ч алдагдалгүй байх хэмжээнд нүүрсний үнийг нэмэгдүүлж чадахгүй байна.

Дэд бүтцийн сайдын 2002 оны 07 тоот тушаалаар батлагдсан түүхий эд, түлш, сэлбэг материалын үнийн өөрчлөлтийг харгалзан нүүрсний үнийг тодорхойлох аргачлалаар тооцож үзэхэд 1 тонн нүүрсний үнэ 31,369.8 төгрөг байвал Багануур ХК нь өртгөө нөхөж, алдагдалгүй ажиллах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломж бүрдэх юм. Багануур ХК нь 2015 оны байдлаар цахилгаан дулааны эрчим хүчний станцуудад 1 тн нүүрсийг 25500 төгрөгөөр борлуулж байсан бөгөөд 1 тонн нүүрсийг 29,038.0 төгрөгөөр гаргаж, борлуулсан нүүрсний тонн тутмаас 3,538.0 төгрөгийн алдагдал хүлээж байгаа юм. Багануур ХК-ий нийт зардлын 49.5%-ийг импортын бараа бүтээгдхүүн эзэлж байгаа бөгөөд долларын ханш 2011 онтой харьцуулахад 64,5%-р, 2012 онтой харьцуулахад 50.8%-р тус тус өссөн байна. Компанийн нийт худалдан авалтын 99.6 хувийг импортын бараа бүтээгдэхүүн эзэлдэг.

Эрчим хүчний нүүрсний өсч буй хэрэгцээг тасралтгүй, найдвартай хангахын тулд техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг зайлшгүй хийх шаардлагатай бөгөөд өнөөгийн мөрдөж байгаа үнэ нь техникийн шинэчлэлийн эх үүсвэрийг

шийдвэрлэх боломжгүй байгаа юм.

Иймд үнэ тогтоох аргачлалыг дараах байдлаар шинэчлэн тооцож, нүүрсний үнийг зах зээлийн нөлөөлөх хүчин зүйлийн өөрчлөлтөөс хамааруулан индексжүүлэх аргачлалыг хэрэгжүүлбэл үр дүнтэй байна гэж үзэж байна.

Үнэ тогтоох аргачлалыг шинэчлэх нь

Одоогийн нүүрсний үнэ тогтоож байгаа аргачлал нь сүүлийн жилүүдэд гарсан зардлын гүйцэтгэлд үндэслэгдсэн байх ба ирээдүйд хийх хөрөнгө оруулалт шинэчлэлийн зардлыг тооцдоггүй. Мөн нүүрсний үнэ тооцох зардалд ажилчдын нийгмийн зардлыг хасч тооцдог. Нүүрс олборлогч компаниудын өртөг зардалд шууд нөлөөлөх хүчин зүйлүүд болох валютын ханшны өөрчлөлт, сэлбэг үнийн бодит өөрчлөлтүүдийн нөлөөллийг тооцдоггүй зэрэг сул талтай. Дэвшүүлж байгаа аргачлалын давуу тал нь нүүрсний үнийг тодорхой хугацаанд индексжүүлэн /өөрчилж нэмэгдүүлэх буюу бууруулах/ мөрдөхөд чиглэгдэх юм.

Нүүрсний үнэ тооцох томъёо:

- А. 1 тонн нүүрсний суурь үнэ нь 2015 оны зардлын задаргааны хүснэгтийн дагуу 25,500 төгрөг (НӨАТ тооцоогүй) байна.
- Б. Нүүрсний үнэд дараах хүчин зүйлсээс хамааран жил тутам өөрчлөлт оруулна:
- Инфляци
 - Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хэлбэлзэл
 - ОХУ-ын түлш, газрын тосны үнийн индекс
 - Эрх бүхий байгууллагаас нүүрсний үнэнд оруулсан өөрчлөлт

Жил бүрийн нүүрсний үнийг тодорхойлох арга (стандарт илчлэгээр)

Нүүрсний үнэд дараах томъёоллын дагуу өөрчлөлт оруулна:

$$Pcif_x = Pcif_{x-1} * \left(1 + 0.5 * \left(\frac{FX_x - FX_{x-1}}{FX_{x-1}} \right) + 0.3 * \left(\frac{MPI_x - MPI_{x-1}}{MPI_{x-1}} \right) + 0.2 * \left(\frac{RPI_x - RPI_{x-1}}{RPI_{x-1}} \right) \right) + (PI_x - PI_{x-1})$$

Дээрх томъёонд:

$Pcif_x$ - 'x' жил дэх нэг тонн нүүрсний үнэ (төгрөгөөр);

$Pcif_{x-1}$ - 'x' жилийн өмнөх 'x-1' жил дэх нэг тонн нүүрсний үнэ (төгрөгөөр);

FX_x - 'x' жил дэх FX

FX_{x-1} - 'x' жилийн өмнөх 'x-1' жил дэх FX

MPI_x - 'x' жил дэх MPI

MPI_{x-1} - 'x' жилийн өмнөх 'x-1' жил дэх MPI

RPI_x - 'x' жил дэх RPI

RPI_{x-1} - 'x' жилийн өмнөх 'x-1' жил дэх RPI

PI_x - 'x' жил дэх PI

PI_{x-1} - 'x' жилийн өмнөх 'x-1' жил дэх PI

«FX» -Жил бүрийн 6-р сарын 30-ний өдрийн Монгол банкны нэг ам.доллартай тэнцэх төгрөгийн ханш.

«MPI»- Жил бүрийн 6 сарын 30-ний өдрийн Монгол Улсын Үндэсний Статистикийн Газрын Монголын Хэрэглээний Үнийн Индекс (2000 он = суурь 100) ,

«RPI» - Жил бүрийн 6 сарын 30-ний өдрийн PLATTS мэдээний “ОХУ-ын түүхий болон бусад нефтийн бүтээгдэхүүний дотоодын зах зээл – суурь үнэ” хэмээх ОХУ-ын түлш, газрын тосны референц үнийн индекс.

“PI” - Монгол Улсын эрчим хүчний нүүрсний үнийг хянаж, тогтоох эрх бүхий байгууллагаас тогтоосон үнэ

Энэ аргачлалыг хэрэглэснээр, одоогийн бодит өртөг зардалд тулгуурлан эрх бүхий байгууллагаас тогтоосон нүүрсний суурь үнэд өөрчлөлт оруулна. Эрчим хүчний зохицуулах хороо нь нүүрсний үнийн зохицуулалтыг улс төрийн нөлөөлөөс хөндийрүүлэх алхам болж, цаашид зохицуулах хороо хэрхэн ажиллахаас бүх зүйл шалтгаалах болно.

Санал, дүгнэлт

Одоогийн нүүрсний үнэ тогтооход хэрэглэж байгаа аргачлал нь сүүлийн жилүүдэд гарсан зардлын гүйцэтгэлд үндэслэгдсэн байх ба ирээдүйд хийх хөрөнгө оруулалт шинэчлэлийн зардлыг тооцдоггүй. Түүнчлэн, нүүрс олборлогч компаниудын өртөг зардалд шууд нөлөөлөх хүчин зүйлүүд болох валютын ханшны өөрчлөлт, сэлбэгийн үнийн өөрчлөлтийн нөлөөллийг тооцдоггүй зэрэг сул талтай.

Иймд энэхүү ажилд дэвшүүлж буй үнэ тооцох аргачлал нь валютын ханш, түлш шатахуун, инфляцийн өсөлт бууралтыг нүүрсний үнэ тооцоололд тусгаж өгснөөрөө давуу талтай юм. Нүүрсний үнийн зохицуулалт, олборлолт, нийлүүлэлт болон дотоодын хэрэглээ зэргийг нэгтгэн шинжилж үзвэл нүүрсний үнийг индексжүүлэх эсвэл чөлөөлөх боломж нэгэнт бүрдсэн тул цаашид үнэ тогтооходоо энэхүү үнийг индексжүүлэх аргачлалыг хэрэгжүүлэх саналтай байна. Ингэснээр компани санхүүгийн чадвартай болж өөрийн хөрөнгөөр техник технологийн шинэчлэл хийж, өсөн нэмэгдэж буй нүүрсний хэрэгцээг хангах боломж бүрдэнэ.

Ашигласан материал:

Багануур ХК ийн өртгийн тайлан 2012-2015 он
Багануур ХК санхүүгийн тайлан тэнцэл 2012-2015 он
АМГ-ын Нүүрсний хэлтсийн жилийн ажлын тайлан
www.coalminig.mn вебсайт
<http://www.erc.mn/erchim-huchnii-une-tarif>